



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/170/СТА/ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn

Аудитор: Н.Бунчинсүрэн

Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	4
Аудитын тайлан.....	6
2.1. Оршил	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.13. Шилэн дансны мэдээлэл	12
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	13
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
Менежментийн захидал	14
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	Error! Bookmark not defined.
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	18
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	20
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	23
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	25



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН Г
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Д.БАТ-ОРШИХ ТАНАА

2020.02.07 № 01/53
танай _____ -ны № _____ -г
Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-г заасны дагуу Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

D:\Bunchinsuren\bunchinsuren-2019\СТА-2019\ТШЗ-9\9.Политехник коллеж-170\4.Тайлангийн үе-170\Аудитын гэрчилгээ.docx

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.МӨНХБАТ

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг коллежийн захирал Д.Бат-Орших танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 01-нээс 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Баянхонгор аймаг Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Политехникийн коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Баялаг бүтээх чадамжтай төгсөгчдийг бэлтгэх"-д оршино.

Баянхонгор Политехник коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Техник боловсрол олгох үйл ажиллагаа
- Тусгай мэргэжил олгох үйл ажиллагаа
- Бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Политехник коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Политехник коллежийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн.

Баянхонгор аймгийн Политехник коллеж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гүүк Софт” ХХК-ны Ахлогер санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Политехник коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Политехник коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 32 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 32 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1537219.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 30744.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 45746.6 мянган төгрөгөөр тооцов.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 294366,9 мянган төгрөгөөр буюу 9,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	30978,1	11942,1	-19035,9
Урьдчилгаа			
Бараа материал	350792,9	370543,7	19750,8
Үндсэн хөрөнгө	4291761,2	4147796,3	-143964,9
Хуримтлагдсан элэгдэл	-1314646,7	-1465763,4	-151116,8
Нийт хөрөнгө	3358885,5	3064518,6	-294366,9
Өр төлбөр	30,0		-30,0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3358885,5	3064518,6	-294336,9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3358885,5	3064518,6	-294366,9

Авлага дансны үлдэгдэл 19035,9 мянган төгрөгөөр буурсан ба 2019 оны жилийн эцсийн байдлаар 11942,1 мянган төгрөгийн авлага байгаа нь "Хонгор хайрханы сүлд" ХХК-иас 4867,5 мянга, Бүдүма ХХК-иас 825,5 мянган төгрөгийн хүнсний авлага, өмнөх оны жолооны сургалтын төлбөрийн авлагаас 5775,0 мянга, ажиллагсдаас авах авлага 460,1 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд 2005-2018 онуудад үүссэн, он удаан жил болсон хувь хүнээс авах 4830,0 мянган төгрөг байна. Энэ авлага нь жолооны төлбөрийн авлага ба үүнээс 1975,0 мянган төгрөг нь эзэн холбогдогч олдохгүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19750,7 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материал 4584,7 мянган төгрөг, хичээл дадлагын барилгын засвар материал 4518,5 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 2248,0 мянган төгрөг, хичээл дадлагын материал 14405,7 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2018 онд худалдаж авсан ашиглаагүй 44679,2 мянган төгрөгийн бараа материал байна. Энэ нь Политехник коллеж нь өмнөх үлдэгдэлээ зарцуулаагүй байхад шинээр бараа материал худалдаж авдаг, үлдэгдэл бараа материалд тавих хяналт хангалтгүйтэй холбоотой байна. Мөн оны эцэст 4584,7 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт заасан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтыг зөрчиж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 143964,9 мянган төгрөгөөр буурсан нь 210605,7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталснаас шалтгаалжээ. Тайлант онд хөрөнгө оруулалтаар 59459,4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 7181,5 мянган төгрөг хөрөнгө худалдаж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3064518,7 мянган төгрөг болж 294336,8 мянган төгрөгөөр буурсан тайлант үеийн үр дүн -294336,8 мянган төгрөг болсноос шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 253334,81 мянган төгрөгийн бичилт нь үндсэн хөрөнгө акталснаас болж дахин үнэлгээний нэмэгдэл буурсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Баянхонгор аймгийн Политехник коллеж нь тайлант онд 31000,0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 12545,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 40,4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төсөвт байгууллагын өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	25500,0	7415,2	18084,8	29,1
Туслах үйл ажиллагааны орлого	5500,0	5130,6	369,4	93,2
Нийт дүн	31000,0	12545,8	18454,2	40,4

Үндсэн үйл ажиллагааны орлого 18084,8 мянган төгрөгөөр тасарсан нь хичээл дадлагаас орох орлогыг багш бүрээр тооцож дүгнэдэггүй мөн багш нарын хийсэн бүтээлийг үнэлж тайланд тусгадаггүйтэй холбоотой.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх мэргэжлийн боловсрол хөтөлбөрт /71804/ зориулан 1754085,7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1754085,7 мянган төгрөгийг урсгал зардалд, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг хөтөлбөрт /80802/ 96134,9 мянган төгрөг, дотуур байрны үйлчилгээ хөтөлбөрт /81806/ 74987,1 мянган төгрөг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1894207,7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 31000,0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд 1925207.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 1807192.1 мянган төгрөгийн урсгал санхүүжилт, өөрийн орлогоор 17375.9 мянган төгрөг орлого орж нийт 1824567.9 мянган төгрөгийн орлоготой, 1824567.9 мянган төгрөгийн зардал гарч 87015.6 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1824567,9 мянган төгрөг буюу 94,8 хувьтай байгаа нь Цалин НДШ 83353,5 мянган төгрөг хэмнэгдсэн 96 орон тоо батлагдсан гүйцэтгэлээр 91 орон тоотой ажилласан ба үр дүнгийн урамшуулал 31692,9 мянган төгрөг хэмнэсэн, Дотуур байрны хүүхдийн хоол 10022,3 мянган төгрөг хэмнэгдсэн нь 150 хүүхдээр төсөв батлагдаж ирсэн гүйцэтгэлээр дунджаар 99 хүүхэд дотуур байранд хамрагдсанаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Сургуульд ажиллаж байгаа Герман багшийн цалингийн зардалд 2441.3 мянга, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудын улсын аварга шалгаруулах волейболын тэмцээнд оролцсон багуудын оролцооны мөнгө 6550.0 мянган төгрөг, оёдлын сургалтын төлбөр 1640.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 15250.0 мянга, улаан загалмайн хорооноос 900.0 мянган төгрөгийн түр сургалтын төлбөрийн орлого, нийт 26781,3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хичээл үйлдвэрлэлийн дадлагад 17641,3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардалд 9140,0 мянга, нийт 26781,3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 31эрсдэл тодорхойлж нийт 31 горим сорил хэрэгжүүллээ.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 31 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 24 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар нийт 40341,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 14122,6 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 26219,2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	5	26219,2	
2	Төлбөрийн акт тогтоосон	7	14122,6	
3	Албан шаардлага өгсөн			
	Дүн	12	40341,8	

Аудитаар дараах 40341,8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 14122,6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд:

1. Д.Бат-Оршиход 2019 оны 1-4 сард үндсэн цалингаас 40 хувиар тооцон 1475,3 мянган төгрөгийн нэмэгдэл цалин нягтлан бодогч олгосон, мөн сургуулийн төгсөлтийн шалгалт, мэргэжлийн зэрэг олгох шалгалтын комиссын даргаар өөрийгөө томилж, тушаал гарган 3 удаа нийт 280 цагийн илүү цаг тооцон 1535.0 төгрөг авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" БСШУ-ны сайдын 2001 оны 157 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Техникийн болон мэргэжлийн анхан, дунд шатны сургууль, төгсөгчдийн боловсролын болон мэргэжлийн зэрэг олгох шалгалтын журам"-ын 3.1 дэх "Төгсөлтийн шалгалтын ерөнхий комиссыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар, салбар комиссыг захирлын тушаалаар байгуулж ажиллуулна", Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 09 сарын 27-ны өдрийн А/198/215 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам"-ын 5.1 дэх "Мэргэжлийн болон техникийн, бүрэн дунд боловсролын төгсөлтийн нэг шалгалтын комиссын гишүүний цагийн гүйцэтгэл нь 50 цагаас ихгүй байх бөгөөд нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 8 хувиас ихгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн, Үнэн зөв толилуулга ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Политехник коллежийн үндэсний магадлан итгэмжлэлд оруулах ажлыг бэлтгэх, судалгаа хийх, төлөвлөх, тайлагнах ажлыг сайтар боловсруулсан нэр бүхий 16 ажилтанд 40 хувийн нэмэгдлийг 2019 оны 9 сарын 26-ны өдрийн захирлын 74 тушаалаар "Боловсролын тухай" хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 26.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 281 дүгээр тогтоолоор батлагдсан "Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.5.6 дахь заалт, "Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.8, 2.3.9 дэх заалт, боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн мэргэжлийн боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2019 оны 06 сарын 01-ний өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн 4552,8 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт, Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2 дахь "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн, "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Хүн амын орлогын албан татварыг 12 дугаар сард ажилтнуудын цалингаас дутуу суутгаж төсвөөс 484,2 мянган төгрөг илүү шилжүүлж, авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1.1 дэх заалт "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4. Багш Э.Нандинцэцэгийн цалингаас суутгалгүй мобиком, багшийн сангийн төлбөрт төсвөөс 234.1 төгрөг шилжүүлж авлагат тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5.5 заалт "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" "Үнэн зөв байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5. Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материалыг бэлтгэн нийлүүлэгч "Хонгор хайрханы сүлд" ХХК-д 2019 оны 12 сарын 13-ны өдөр хүнсний материалын үнэнд 9452.2 төгрөг шилжүүлж, 4584.7 мянган төгрөгийн хүнсний материал авсан нь тайланд үлдэгдлээр тусгагдсан, харин үлдэгдэл 4867.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх Засгийн газрын 2012 оны 10 сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолын 4 дэх "Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг нь тооцож байх" гэсэн заалтыг зөрчсөн Оршин байх, Эрх ба үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

6. 2019 оны эхэнд Бүдүма ХХК-аас 4133.9 мянган төгрөгийн хүнсний материалын авлагатай байснаас 825.5 мянган төгрөг бүрэн барагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн, Оршин байх, Эрх ба үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

7. Ерөнхий нягтлан бодогч Ц.Цэвээнсүрэн Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын 2019 оны 1 сарын 25-ны өдрийн 5/120 тоот тушаалаар сар бүр 25 хувийн ур чадварын нэмэгдэл авч байхад сургуулийн захирлын 2019 оны 11 сарын 20-ны өдрийн 77 дугаар тушаалаар 11 сард 20 хувийн нэмэгдэл 147,7 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Засгийн газрын 382 дугаар тогтоолын хавсралт 4. Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмын 3 дахь заалт "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 26219,2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сурагчдын хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалын зарлагыг гаргахдаа дадлагын хичээлээр багш бүрээр тооцож, шаардах хуудас бичиж, гүйцэтгэлээр үр дүнг тооцож хичээл дадлагын орлогыг тухай бүр нь оруулаагүй байна. Шатахууныг зарцуулахдаа норм нормативын дагуу явсан км, зарцуулсан шатахууныг тухай бүр тооцож үздэггүй.

Цаашид хичээл дадлагын материалын зардлыг хичээл тус бүрээр үр дүнг тооцсон, дансанд бүртгэлтэй байгаа бараа материалын үлдэгдлийн тооцоо, тооллогыг үнэн зөв хийсэн эсэх, Аймгийн Засаг даргын 2013 оны 327 дугаар захирамжаар баталсан "Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам"-ыг мөрдөж шатахууны зардлыг гаргасан, авлага өглөгийг бүрэн барагдуулж тайлант зөв тусгасан эсэхийг тус тус анхаарч давтан шалгаж авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	5	3	3
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	32	4	
5	Тухай бүр	8	96	94	2	
6	Нийт	27	151	138	10	3

Хугацаа хоцроож байршуулсан дараахь мэдээлэлүүд байна..

Дараа жилийн төсвийн төсөл /бүтэн жилээр/-1, төсөвт байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /9,10 сар,3-р улирал/-3, тухайн жилд төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /9 сар/-1, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө /бүтэн жил/-1, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессийн зүйлийн жагсаалт гүйцэтгэл /10 сар/-1, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл-1, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /бүтэн жилээр/-1, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /10 сар/-1 нийт хугацаа хоцроосон 10 мэдээлэл байна

Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан/бүтэн жилээр/-1, санхүүгийн тайлан /бүтэн жилээр/-1, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /бүтэн жилээр/-1 нийт 3 мэдээлэл байршуулаагүй байна

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 853.0 мянган төгрөгийн зөрчилд 853.0 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан байна.

Нийт зөрчил арилгах 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан тухай 2019 оны 10 сарын 8-ны өдрийн 156 албан тоотоор ирүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Политехник коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

